

**ДҮРСЛЭХ, ДИЗАЙН УРЛАГИЙН САЛБАРЫН ХҮНИЙ  
НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**



**ДҮРСЛЭХ УРЛАГ**



**ДИЗАЙН УРЛАГ**

**УЛААНБААТАР ХОТ**

**2021 ОН**

## АГУУЛГА

<b>УДИРТГАЛ</b> .....	3
Судалгаа хийх хийх үндэслэл, зорилт, ач холбогдол .....	3
Судалгааны арга зүй .....	3
Судалгааны ажлын зохион байгуулалт.....	4
Мэдээллийн эх үүсвэр.....	4
<b>Бүлэг 1. Дүрслэх, дизайны салбарын түүхэн хөгжлийн зураглал</b> .....	5
1.1 Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн талаархи бодлогын хэрэгжилт .....	5
<b>Бүлэг 2. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл ба соёл, урлагийн салбар: Дүрслэх, дизайны салбарын ажиллагчдын өнөөгийн байдал</b> .....	7
2.1 Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амын төлөв байдал .....	7
2.2 Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд соёл, урлагийн салбарын төлөв байдал .....	9
2.3 Соёл урлагийн хөдөлмөрийн зах зээл: Дүрслэх, дизайн урлагийн салбарын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал .....	13
2.4 Дүрслэх, дизайны мэргэжлээр ажил хайгч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн өнөөгийн байдал .....	23
<b>Бүлэг 3. Дүрслэх, дизайн урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж буй байдал</b> .....	25
3.1 Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын байдал.....	28
3.2. Дүрслэх, дизайны чиглэлээр их, дээд сургууль төгсөгчид .....	45
<b>Бүлэг 4. Дүрслэх, дизайн урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж буй байдал</b> .....	50
4.1.Дүрслэх, дизайны чиглэлээр техник, мэргэжлийн боловсролын байгууллага (сургалтын байгууллага)-д суралцагчдын байдал .....	50
4.2. Дүрслэх, дизайны чиглэлээр мэргэжлийн, техник боловсролын байгууллага болон сургалт, үйл ажиллагааны төвүүд, тэдгээрийг төгсөгчид.....	63
<b>Бүлэг 5. Дүрслэх, дизайн урлагийн салбарын чиглэлээрх ААНБ-ын өнөөгийн байдал</b> .....	67
<b>Бүлэг 7. Дүрслэх, дизайн урлагийн эрх зүйн орчинд хийсэн шинжилгээ</b> .....	72
<b>ДҮГНЭЛТ, САНАЛ</b> .....	74
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>ХАВСРАЛТ</b> .....	77

## УДИРТГАЛ

Судалгаа хийх хийх үндэслэл, зорилт, ач холбогдол

Монгол Улсын Соёлын яамны захиалгаар хэрэгжүүлж буй “Дүрслэх, дизайн урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ”-ний ажлын даалгаврын хүрээнд энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын зорилго нь Соёл урлагийн салбарын Дүрслэх, дизайн урлагийн хүний нөөцийн талаарх 2010-2021 оны хугацааны мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, салбарын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын эрэлт хэрэгцээ, өөрчлөлтийг судалж, дүгнэлт гаргахад оршино.

Энэхүү судалгаанд Дүрслэх, дизайн урлагийн хүний нөөцийн талаарх сүүлийн 5 жилийн буюу 2017-2021 оны статистикийн мэдээллийг нэгж байгууллагын түвшинд задлан дүн шинжилгээ, эрх зүйн орчны SWOT шинжилгээгээр баяжуулснаар гол ач холбогдол нь оршиж байгаа болно.

Дүн шинжилгээг дараах үндсэн 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

- *Дүн шинжилгээ хийх үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлох шинжилгээ*

Дүрслэх, дизайн урлагийн салбарын 2010-2021 оны нөхцөл байдлыг илэрхийлэх хүний нөөцийн үзүүлэлтүүдийн нэгдсэн хүрээг гаргасан. Соёл, урлагийн салбарын хөгжлийн бодлого болон салбарын хууль эрх зүй, бодлогын баримт бичигт туссан зорилт, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлттэй уялдуулах байдлаар агуулгыг тодорхойлсон.

- *Статистикийн тоон мэдээллийн шинжилгээ*

Хөдөлмөр эрхлэлт, боловсролын салбарын албан ёсны болон захиргааны статистикийн мэдээлэл, Ажиллах хүчний түүвэр судалгаа, ХАОСТ-2020-ын нэгдсэн үр дүнгийн мэдээллүүд бүхий хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг ашиглан Дүрслэх, дизайн урлагийн салбарын хүний нөөцийн мэдээллийг 2010-2021 оны байдлаар хүйс, байршил, насны бүлэг, аймаг, нийслэл, дүүрэг, өмчийн хэлбэр зэрэг үндсэн задаргаагаар харьцуулан, дүн шинжилгээ хийсэн.

- *Дүгнэлт гаргах, санал боловсруулах*

Статистик тоон мэдээллийн харьцуулсан дүн шинжилгээгээр гарсан үр дүнд үндэслэн дүгнэлт гаргаж, холбогдох санал, зөвлөмжийг боловсруулсан.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажил нь хайгуул судалгааны аргад үндэслэн дүрслэх, дизайн урлагийн салбарын хүний нөөцийн сүүлийн 5 жилийн өнөөгийн байдал, хөгжил, цаашдын эрэлт хэрэгцээний үзүүлэлтийн үр дүнг илэрхийлэх албан ёсны, захиргааны статистик тоон мэдээлэл болон холбогдох бусад судалгааны ажлын мэдээллийг ашиглах арга зүйг баримтлан ажилласан.

Тус арга зүйгээр одоогийн бэлэн байгаа дүрслэх, дизайн урлагийн салбарын хүний нөөцийн үндсэн үзүүлэлтийн чиг хандлагыг динамик эгнээгээр, нэгтгэн үндсэн үзүүлэлтүүдийн бүтэц өөрчлөлт, дүрслэх, дизайн урлагийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээ, өөрчлөлтийг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. Судалгааны ажлын үр дүнг захиалагч талд танилцуулан, саналыг тусган дүгнэсэн. Судалгаанд ашигласан дээрх арга зүй, аргачлалыг нэгтгэн томъёолсон судалгааны ажлын дизайныг дараах зурагт харууллаа.

**Зураг 1. Судалгааны ажлын дизайн**



### Судалгааны ажлын зохион байгуулалт

Судалгааны ажлыг хүний нөөцийг чадавхжуулах сургалт, судалгааны чиглэлээр 2000 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа “Саруул ирээдүйн хөтөч” ХХК-ийн мэргэшсэн судлаачдын баг хариуцан зохион байгуулж хийж гүйцэтгэв.

### Мэдээллийн эх үүсвэр

1. Боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн салбарын захиргааны статистикийн мэдээллийг 2010-2021 оноор, улс, бүс, байршлаар авч үзэн, дүн шинжилгээ хийж, Дүрслэх, дизайн урлагийн салбарын хүний нөөцийн бүтэц, өөрчлөлт, хөгжилтэй холбогдох үзүүлэлтүүдийг боловсролын салбарын мэдээллийн системийн мэдээллийн санг ашиглан тооцсон. Үүнээс гадна Дүрслэх, дизайн урлагийн салбарын чиглэлээр хийгдсэн бусад судалгаа, шинжилгээний ажлын үндсэн үр дүнг ашигласан.

2. Үндэсний статистикийн хорооны Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын–Нэгдсэн дүн” болон Ажиллах хүчний түүвэр судалгааны тайланг үндсэн эх үүсвэр болгон ашигласан.


## Бүлэг 1. Дүрслэх, дизайны салбарын түүхэн хөгжлийн зураглал

### 1.1. Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн талаархи бодлогын хэрэгжилт

БНМАУ-ын анхдугаар үндсэн хуулиар (1924) “Жинхэнэ ард нийтээр хуралдах, цэнгэлдэх ба баяр ёслол үйлдэх явдлыг хүндэтгэж, олон ардыг аливаа эрдэм соёлд гэгээрүүлэх замыг нээгдүүлэн, үнэ төлбөргүйгээр боловсруулах явдлыг гүйцэтгэвэл зохино” хэмээн зааж, бүх нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн албан ёсны бодлого болгон явуулах хууль, эрх зүйн үндсийг тавьсан. Мөн “Ардыг Гэгээрүүлэх Яамны дүрэм”-д газар бүр номын сан байгуулан аливаа бичиг зүйлийг сонирхон уншиж үзэхэд бэлтгэх, хуучны аливаа зүйлийн сонин юм ба газар орны эд бодисыг цуглуулан хурааж, музей хэмээх үзэсгэлэнгийн газруудыг бэлтгүүлэх, жүжиг, наадам, дуу хөгжим, цахилгаан сүүдрийн зураг гаргах, Улаан гэр, клуб, улаан буланг өргөтгөх” зэрэг заалтуудыг тусган хэрэгжүүлж иржээ.

Улаан гэр, клубээс эрдмийн театр, чуулга, гэрийн гар урлалаас галлерей, музей, ном уншлагаас номын сан хүртэл өргөн дэлгэр бүтэц бүхий орчин цагийн соёл, урлагийн салбарын бие даасан тогтолцоо үүсч хөгжих явцад соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз бэхжиж, үндэсний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэж ирсэн байна.

**Зураг 3.1. Соёл, урлагийн салбарт мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэсэн цаглабар**



Эх үүсвэр: **Судалгааны багийн боловсруулснаар**

**Дүрслэх урлагийн мэргэжилтэн бэлтгэгдсэн нь:** Төр засгаас ардын гар урчууд, авъяастныг мэргэшүүлэх, дүрслэх урлагийн мэргэжилтэнг гадаад, дотоодод бэлтгэх, мэргэжлийн сургууль байгуулах талаар анхаарч удаа дараа тогтмол шийдвэр гарган хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, НТХ-ны бүгд хурлын 1940.12.20-ны тогтоолд “Клубүүдийг сайн дурын ажилчдаар хангаж, олон нийтийн ажлыг хүчтэй болгох, уран зохиолчид, зураачдыг хөдөөд олшруулах”<sup>1</sup>, “Аймгийн төвүүдэд уран зураг ба гэрэл зургийн газрыг байгуулан түүнийг удирдах хүмүүсийг бэлтгэх зорилгоор уран зураач, гэрэл зурагчдыг бэлтгэх курсыг 1946 онд зохион байгуулах”<sup>2</sup>, уран сайхны сургуулийн сурагчдыг авах явдалд хэдийгээр ерөнхий боловсролгүй боловч авъяас чадвартай хүмүүсийг авах нь чухал тул үүнийг бүхий л талаар шалган үзэж байваас зохино. Энэхүү сургуулийн хугацаа нь жил тутам батжин нэмэгдсээр 5-6 жилийн хугацаатай болох ёстой...”<sup>3</sup> гэжээ. Энэхүү бодлого нь урлагийн мэргэжлийн дунд, дээд сургууль байгуулах, дүрслэх урлагийн мэргэжилтэй боловсон хүчнийг гадаад, дотоодод бэлтгэх өргөн далайцтай үйл ажиллагаа болсон.

МАХН-ын X их хурлаар “Урлагийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, театр, клуб зэрэг уран сайхны байгууллагуудын ажиллагааг сайжруулах, ажилчдаар хангах зорилгоор жүжиг, хөгжим, дуу бүжиг, дүрслэх урлагийн сургуулиудыг байгуулж улсаас санхүүжүүлж байх”<sup>4</sup> асуудлыг шийдвэрлэжээ. 1945-1946 оны хичээлийн жилд уран зураач, уран барималчдийн сургуулийг “зураг урлал”-ын газрын дэргэд байгуулах, цирк, зураг урлал, театрын дэргэдэх сургуулиудад бага сургуулийн бүрэн боловсролтой хүмүүсийг элсүүлэх, сургах хугацаа нь 3-5 жил байх, НТХ-ны Улс Төрийн Товчоо (УТТ)-ны хурлын 1954.8.16-ны 42/243 тогтоолоор “зураачдын мэргэжлийг дээшлүүлэхийн тулд дүрслэх урлагийн газарт төлөвлөгөөтэйгээр сургалт зохион байгуулж, авъяаслаг зураачдаас жил бүр 2 хүнийг ЗХУ-д суралцуулахаар шийдвэрлэж байжээ. Ийнхүү системтэй арга хэмжээний үрээр 1945 онд дүрслэх урлагийн дунд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх сургууль байгуулагдаж, 1971 онд Дүрслэх урлагийн дунд сургууль, 1992 онд Дүрслэх урлагийн коллеж, 1996 онд СУИС-ийн урлахуй ухааны сургалт, эрдэм шинжилгээний төв, 1998 онд Дүрслэх урлагийн дээд сургууль, 2010 онд СУИС-ийн Дүрслэх, дизайн урлагийн сургууль байгуулагдаж 2021 онд “Дүрслэх урлагийн академи” дээд сургууль болж өнөөг хүрсэн байна.

---

<sup>1</sup> МАХН-аас урлаг, утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэрүүд (1921-1966), УБ.1967.23тал

<sup>2</sup> Мөн тэнд. 23тал

<sup>3</sup> Мөн тэнд. 67тал


<sup>4</sup> Мөн тэнд. 23тал

## Бүлэг 2. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл ба соёл, урлагийн салбар: Дүрслэх, дизайны салбарын ажиллагчдын өнөөгийн байдал

### 2.1 Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амын төлөв байдал

Манай Улсын хүн ам 2016 онд 3119.9 мянга байсан бол 2020 онд 3357.5 мянгад хүрч 7.6 хувиар өссөн байна. Сүүлийн 5 жилийн байдлаар хүн амын дундаж өсөлт 1.9% байна.

Зураг 1. Нийт хүн ам, түүний өсөлтийн хувь, 2016-2020 он



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хүн амыг бүсээр харахад 2020 оны байдлаар нийт хүн амын 1597.3 (47.6%) нь Улаанбаатар хотод амьдарч байна. Харин Зүүн бүсэд нийт хүн амын хамгийн бага нь 225.1 (6.7%) нь амьдарч байна. Хот хөдөөгөөр харахад, нийт хүн амын 2316.5 (69.0%) нь хотод, 1041.0 (31.0%) нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Хүснэгт 1. Нийт хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр, 2016-2020 он

Байршлаар	Аймаг	2016	2017	2018	2019	2020
Бүгд	Улсын дүн	3,119,935	3,177,899	3,238,479	3,296,866	3,357,542
	Баруун бүс	393,069	400,703	408,979	412,036	415,091
	Хангайн бүс	582,873	593,645	604,353	605,216	604,200

	Төвийн бүс	492,494	504,319	513,438	516,611	515,880
	Зүүн бүс	211,052	216,259	220,334	223,193	225,081
	Улаанбаатар	1,440,447	1,462,973	1,491,375	1,539,810	1,597,290
Хот	Улсын дүн	2,131,823	2,146,716	2,197,970	2,258,981	2,316,499
	Баруун бүс	127,492	130,265	135,803	138,256	139,114
	Хангайн бүс	232,168	234,451	245,062	250,581	250,184
	Төвийн бүс	245,593	229,100	234,289	236,990	236,571
	Зүүн бүс	86,123	89,927	91,441	93,344	93,340
	Улаанбаатар	1,440,447	1,462,973	1,491,375	1,539,810	1,597,290
Хөдөө	Улсын дүн	988,112	1,031,183	1,040,509	1,037,885	1,041,043
	Баруун бүс	265,577	270,438	273,176	273,780	275,977
	Хангайн бүс	350,705	359,194	359,291	354,635	354,016
	Төвийн бүс	246,901	275,219	279,149	279,621	279,309
	Зүүн бүс	124,929	126,332	128,893	129,849	131,741

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Үндэсний статистикийн хорооноос жил бүр тогтмол явуулдаг “Ажиллах хүчний судалгаа” нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг илэрхийлэх үндэсний хэмжээний мэдээллийн гол эх үүсвэр юм. Тус судалгааны сүүлийн 5 жилийн байдлаарх үр дүнг дараах хүснэгтээс харахад 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх хэлбэлзэж байсан нь ажиллах хүчний оролцооны түвшний өсөлт, бууралтаас харагдаж байна.

Ажиллах хүчний түвшин болон оролцооны хэв маяг нь хөдөлмөр эрхлэх боломжууд болон орлогын эрэлт хэрэгцээнээс шалтгаалдаг хэдий ч хүн ам зүйн ангилал хооронд ялгаатай байх талтай. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин бүх талаараа буюу насны бүлэг, гэр бүлийн байдал, боловсролын түвшний хувьд эрэгтэйчүүдийнхээс их ялгаатай байдаг. Түүнчлэн хот, хөдөөгийн хүн амын оролцооны түвшин ч гэсэн их зөрүүтэй байдаг байна.

Ажиллах хүчний судалгааны 2019 оны үр дүнгээр 15 ба түүнээс дээш насны ажиллагчдыг 2016 онтой харьцуулахад 0.1 хувиар өсөж, 1273.9 мянгад хүрчээ. Харин 2021 оны 1-р улирлын байдлаар нийт ажиллагчдын тоо 1156.1 мянгад хүрч 2019 оны жилийн эцсийн байдлаас 117.9 (9.3%) мянгаар буурсан дүр зурагтай байна.

Манай улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2016 онд 54.5 хувь байсан бол 2021 оны 1-р улирлын байдлаар 50.1 хувь болж 4.4 пунктээр, харин 2019 оны жилийн эцсийн байдлаас 4.3 пунктээр тус тус буурсан байдал ажиглагдаж байна. Эндээс харахад нийт хүн амын дундах ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурсан нь Ковид-19 цар тахлын онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор, хөл хорио, ААНБ-уудын үйл ажиллагаа хэвийн бус үргэлжилж байгаатай холбоотой байж болох талтай.

Хүснэгт 2. 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх, 2016-2021

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2021-I
Ажиллах хүч	1,275,650	1,357,425	1,358,637	1,273,896	1,156,050



Ажиллагчид	1,147,843	1,238,333	1,253,023	1,146,160	1,054,889
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	-	-	-	15,098.	6,328
Ажилгүй хүн	127,807.	119,092.	105,614.	127,736.	101,161
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	831,366.	862,988.	867,959.	832,183.	949,670
Боломжит ажиллах хүч	-	-	-	58,800.	108,799
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	-	-	-	773,383.	840,871
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	60.5	61.1	61.	60.5	54.9
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	54.5	55.8	56.3	54.4	50.1
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	-	-	-	15.1	17.1
Ажилгүйдлийн түвшин, %	10	8.8	7.8	10.	8.8
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	-	-	-	11.2	9.3
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	-	-	-	14.	16.6

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Тухайн үеийн ажиллагчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар гаргаж, доорх зурагт харууллаа. 2016 онд ажиллагчдын хамгийн их буюу 30.4 хувь (348.5 мянга) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, хамгийн бага буюу 0.1 хувь нь Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт (1.1 мянга), мөн хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагааны (1.1 мянга) салбаруудад тус тус хөдөлмөр эрхэлж байна. Харин 2021 оны эхний улирлын байдлаар ажиллагчдын хамгийн их буюу 28.7 хувь (303.1 мянга) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, хамгийн бага буюу 0.2 хувь нь Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт (1.7 мянга), мөн хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагааны (2.4 мянга) салбаруудад тус тус хөдөлмөр эрхэлж байна.

## **2.2 Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд соёл, урлагийн салбарын төлөв байдал**

Урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагааны салбарт 2016 онд нийт ажиллагчдын 10.1 мянга (0.9%) нь ажиллаж байсан бол 2019 онд 18.0 мянга (1.6%) нь ажиллаж, тус салбарт ажиллагчид өнгөрсөн 4 жилийн хугацаанд 7.9 мянга (78.4%)-аар өссөн байна.

Харин 2021 оны эхний улиралд Урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагааны салбарт 8.8 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагчдын 0.8 хувийг эзэлж байна.

Харин Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчдыг бүсээр харахад 2016 онд Улаанбаатар хотод тус салбарын нийт ажиллагчдын 58.2 хувь нь ажиллаж байсан бол 2019 онд 58.0 хувь болж 0.2 пунктээр буурсан байна. Харин Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчид 2016 оноос 2019 онд Хангайн бүсэд 0.8 пунктээр, Төвийн бүсэд 3.2 пунктээр тус тус өссөн байна. Зүүн бүсэд тус салбарт ажиллагчид 2016 онд нийт ажиллагчдын 4.3 хувь нь ажиллаж байсан бол 2019 онд 1.3 хувь болж 3 пунктээр буурсан байна.

2021 оны 1-р улирлын байдлаар Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчдын 32.1 хувь нь Улаанбаатар хотод байгаа бол хамгийн бага нь буюу 5.0 хувь нь Зүүн бүсэд ажиллаж байна.

Зураг 2. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2016, 2021-I улирал




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 3. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2016-2021-I

<b>Салбар</b>	<b>2016</b>	<b>2017</b>	<b>2018</b>	<b>2019</b>	<b>2021-I</b>
Бүгд	1,147,843.	1,238,333.	1,253,023.	1,146,161.	1,054,887.
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	10,090.	10,104.	13,835.	17,999.	8,779.
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	348,487.	356,423.	334,101.	290,160.	303,070.
Уул уурхай, олборлолт	38,205.	52,017.	57,687.	57,923.	48,994.
Боловсруулах үйлдвэрлэл	86,103.	93,062.	100,805.	90,378.	79,223.
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	16,162.	17,458.	16,307.	19,348.	17,042.
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	6,031.	4,864.	6,869.	10,786.	11,385.
Барилга	71,482.	70,604.	76,596.	68,847.	60,488.
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	172,670.	204,474.	211,187.	160,405.	139,170.
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	65,932.	72,702.	73,567.	61,123.	51,091.
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	32,142.	36,449.	37,484.	36,280.	34,845.
Мэдээлэл, холбоо	18,133.	14,490.	14,089.	13,019.	10,028.
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	21,863.	24,120.	25,689.	24,257.	23,556.
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	767.	379.	770.	1,154.	996.
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12,676.	12,743.	14,608.	18,031.	9,489.
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	15,039.	20,832.	18,185.	20,163.	21,746.
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	74,179.	82,236.	76,197.	85,965.	76,285.
Боловсрол	94,989.	98,876.	98,738.	96,108.	86,260.
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	40,981.	39,973.	49,462.	44,376.	45,112.
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	19,753.	22,728.	23,364.	24,547.	23,236.
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	1,059.	2,294.	1,226.	3,275.	2,410.
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1,100.	1,505.	2,256.	2,014.	1,688.

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Зураг 3. Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарын ажиллагчид, дүнд эзлэх хувиар, 2016-2021 он



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 4. Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчид, бүсээр, 2016-2021

Бүс	2016	2017	2018	2019	2021-I
<b>Нийт</b>	10,090	10,104	13,835	17,999	8,779
Баруун	1,500	1,322	1,311	2,523	1,572
Хангай	1,366	1,226	1,527	2,588	2,951
Төвийн	922	1,520	1,613	2,214	1,000
Зүүн	432	607	672	241	438
Улаанбаатар	5,870	5,429	8,712	10,433	2,818

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 5. Нийт ажиллагчид ба Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчид, хүйсээр, 2016-2021


Хүйс	2016	2017	2018	2019	2021-I
<b>Нийт ажиллагчид</b>	1,147,843	1,238,333	1,253,023	1,146,161	1,054,887
Эрэгтэй	603,885	652,673	669,643	606,814	553,827
Эмэгтэй	543,959	585,661	583,380	539,347	501,060
<b>Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчид</b>	10,090	10,104	13,835	17,999	8,779
Эрэгтэй	4,995	5,503	6,909	7,102	5,861
Эмэгтэй	5,095	4,602	6,925	10,897	2,918

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

2016 онд Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт нийт ажиллаж буй 10090 хүний 5095 (50.5%) нь эмэгтэйчүүд байсан бол 2019 оны байдлаар тус салбарт ажиллагчдын 10897 (60.5%) нь эмэгтэйчүүд байна. Эндээс харахад жил ирэх тусам Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт эмэгтэйчүүдийн ажиллах хувь өссөөр байна.

Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт 2016 онд ажиллагчдын 70.7 хувь нь 25-44 насныхан байсан бол 2019 онд энэ үзүүлэлт буурч 62.0 хувь болсон байна. Харин 45-49 насны ажиллагчдын эзлэх хувь 2019 оноос 8.2 пунктээр өсөж, 25-29 насны бүлгийн ажиллагчид 11.6 пунктээр буурсан дүр зураг ажиллагдаж байгаа нь Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчид ажиллах залуучуудын хувь буурч, насны бүтцийн хувьд идэр, ахмад настнууд нэмэгдэх байдал ажиллагдаж байна.

Зураг 4. Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчид, насны бүлгээр, 2016-2021



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

### 2.3 Соёл урлагийн хөдөлмөрийн зах зээл: Дүрслэх, дизайн урлагийн салбарын хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал

Нийт урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчдаас дүрслэх, дизайн урлагийн чиглэлийн салбарт ажиллагчдаар илүү нарийвчлан судаллаа.

Ажиллах хүчний судалгааны дүнгээр 2016 онд нийт 28422 ажиллагч Дүрслэх, дизайн урлагийн чиглэлийн салбарт ажиллаж байсан бол 2019 онд 29724 болж 1303 (4.6%)-аар өссөн байна. Энэ нь салбарын ажиллагчид, хүний нөөц жил ирэх тусам нэмэгдэж байгаа төлөвийг харуулж байна. Салбарын ангиллаар нийт ажиллагчдын тооны өсөлтийг харахад, Номын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагааны салбарт ажиллагчид 2016 онд 131 байсан бол 2019 онд 835 болж, 704 (6.4 дахин их)-аар, Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэлийн салбарт 2016 онд нийт 4443 ажиллагч байсан бол 2019 онд 6648 болж, 2205 (49.6%)-аар, Хувцаснаас бусад нэхмэл болон сүлжмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарт 2016 онд 553 ажиллагч байсан бол 2019 онд 829 болж, 276 (49.8%)-аар тус тус өссөн байна. Харин Нэхмэл болон сүлжмэл даавуу үйлдвэрлэлийн

салбарт 2016 онд 3045 ажиллагч ажиллаж байсан бол 2019 онд 1705 болж, 1339 (44.0%)-аар буурсан байна.

Хүснэгт 6. Дүрслэх, дизайн урлагийн салбарт ажиллаж байгаа ажиллагчид, 2016-2019 он

<b>Салбарын ангилал</b>	<b>2016</b>	<b>2017</b>	<b>2018</b>	<b>2019</b>
Нэхмэл болон сүлжмэл даавуу үйлдвэрлэл	3045	1383	2670	1705
Хувцаснаас бусад нэхмэл болон сүлжмэл эдлэл үйлдвэрлэл	553	977	438	829
Хивс, хивсэнцэр үйлдвэрлэл	1568	409	768	1647
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	10711	13855	14716	11512
Үслэг арьсан эдлэл үйлдвэрлэл	862	1497	631	704
Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл	4443	4420	4742	6648
Гутал үйлдвэрлэл	4565	4644	5105	3507
Номын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	131	-	72	835
Мэргэжлийн дизайны үйл ажиллагаа	455	-	-	-
Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	2090	1486	3602	2338
Бүгд	28422	28671	32745	29724

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

Нийт Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчдыг Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээрх мэргэжлийн ажиллагчдаар илүү нарийвчлан судаллаа.

Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр 2016 оны байдлаар дүрслэх дизайн урлагийн чиглэлээр ажил мэргэжил эзэмшсэн нийт 34065 ажиллагч байсан бол 2019 оны байдлаар энэ үзүүлэлт 36550 болж 2484 (7.3%) ажиллагчаар өссөн байна.

Нийт дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдын дунд оёдолчин, хатгамалчин, гуталчин, дүрслэх урлаач, Нэхмэл, арьс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан, гар урлалын ажилтан, Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин, Дотоод засал чимэглэлийн архитектурч, хувцасны дизайн мэргэжилтэй ажиллагчид хамгийн өндөр байна.

Харин 2016 оны байдлаар дизайн урлагийн чиглэлээр ажиллагчид дунд Оёдолчин, хатгамалчин болон түүнтэй дүйцэх мэргэжилтэй бусад ажилтан хамгийн өндөр буюу нийт дүрслэх дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдын 2 хүн тутмын нэг нь (50.9%) байсан. Энэ байдал сүүлийн 4 жилийн хугацаанд ч хэвээр хадгалагдаж байна.

Мөн Гуталчин, түүнтэй холбогдох бусад ажилтнуудын нийт дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажилтнуудын дунд эзлэх хувь 2016 онд 11.4 хувь байсан бол 2019 онд 7.8 хувь болж 3.5 хувиар буурсан байна.

Дүрслэх урлаач мэргэжилтэй ажиллагчид 2016 онд нийт 1645 байсан бол 2018 онд 2940 болж 1295-аар өссөн байна. Харин Энэ үзүүлэлт 2019 онд 731 болж 4 дахин буурсан дүр зураг байна.

2016 онд Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдын 1134 (3.3%) нь Нэхмэл, арьс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан байсан бол 2019 онд 1014 (2.8%) болж буурсан байна.

2016 онд Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдын 804 (2.4%) нь Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин байсан бол 2019 онд 2201 (6.0%) болж өссөн байна.

2016 онд Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдын 475 (1.4%) нь Дотоод засал чимэглэлийн архитектурч байсан бол 2019 онд 1477 (4.0%) болж өссөн байна.

2016 онд Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдын 713 (2.1%) нь хувцасны дизайн мэргэжилтэй ажиллагч байсан бол 2019 онд 1487 (4.1%) болж өссөн байна.

Зураг 5. Дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчид, мэргэжлийн чиглэлээр, Дүнд эзлэх хувь, 2016-2020



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа



**Зураг 7. Дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчид, мэргэжлийн чиглэлээр, 2016-2020**

Код	Ажил, мэргэжлийн нэр	2016	2017	2018	2019	2020
2161	Архитектурч, дотоод засал чимэглэлийн	475	1277	1607	1477	
2163	Бүтээгдэхүүн, хувцасны дизайн	713	738	433	1487	
2165	Зурагзүй, байрзүйч	467	969	714	180	
2166	График, мультимедиа зохиомжийн дизайн	614	768	892	1510	
2651	Дүрслэх урлаач	1645	1269	2940	731	
2354	Дуу хөгжмийн багш	1249	854	1506	859	
2355	Соёл, урлагийн багш	326	397	526	609	
3432	Дизайн, дотоод засал чимэглэлийн	81	173	614	537	
7311	Нарийн багаж хийгч, засварчин	360	665	188	384	
7312	Хөгжмийн зэмсэг хийгч, хөглөгч	325	169	86	71	
7313	Эрдэнийн чулуу ба үнэт металлын ажилтан	529	182	232	0	
7314	Ваар, шавар эдлэл хийгч ба холбогдох мэргэжлийн	277	152	78	0	
7315	Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч	525	0	0	354	
7316	Тэмдэг бичигч, гоёл чимэглэлийн будагчин, сийлэгч ба хорын сийлбэрч	75	0	352	780	
7317	Мод, сүлжээс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	552	181	724	25	
7318	Нэхмэл, арьс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	1134	1064	1158	1014	
7319	Өөр газар ангилагдаагүй гар урлалын ажилтан	977	371	576	192	
7321	Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч	620	255	341	1005	
7322	Хэвлэгч	643	372	422	542	
7323	Хэвлэлтийг төгс болгох, дэвтэрлэх ажилтан	74	349	0	534	
7531	Загварчин, үслэг эдлэл, малгай хийгч	0	154	54	37	
7532	Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин	804	369	387	2201	
7533	Оёдолчин, хатгамалчин, бусад ажилтан	17333	21648	20598	17992	
7534	Тавилганы бүрээс хийгч, бусад холбогдох ажилтан	166	79	0	150	
7535	Ангийн үс, арьс шир боловсруулагч	233	408	556	1015	
7536	Гуталчин, холбогдох бусад ажилтан	3870	3609	4606	2864	
	<b>Бүгд</b>	<b>34065</b>	<b>36472</b>	<b>39589</b>	<b>36550</b>	

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

**Хүснэгт 8. Дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчид, мэргэжлийн чиглэлээр, дүнд эзлэх хувь, 2016-2020**

Ажил, мэргэжлийн нэр	2016	2017	2018	2019	2020
Архитектурч, дотоод засал чимэглэлийн	1.4	3.5	4.1	4.0	
Бүтээгдэхүүн, хувцасны дизайн	2.1	2.0	1.1	4.1	

Зурагзүй, байрзүйч	1.4	2.7	1.8	0.5
График, мультимедиа зохиомжийн дизайн	1.8	2.1	2.3	4.1
Дүрслэх урлаач	4.8	3.5	7.4	2.0
Дуу хөгжмийн багш	3.7	2.3	3.8	2.3
Соёл, урлагийн багш	1.0	1.1	1.3	1.7
Дизайнч, дотоод засал чимэглэлийн	0.2	0.5	1.6	1.5
Нарийн багаж хийгч, засварчин	1.1	1.8	0.5	1.1
Хөгжмийн зэмсэг хийгч, хөглөгч	1.0	0.5	0.2	0.2
Эрдэнийн чулуу ба үнэт металлын ажилтан	1.6	0.5	0.6	0.0
Ваар, шавар эдлэл хийгч ба холбогдох мэргэжлийн	0.8	0.4	0.2	0.0
Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч	1.5	0.0	0.0	1.0
Тэмдэг бичигч, гоёл чимэглэлийн будагчин, сийлэгч ба хорын сийлбэрч	0.2	0.0	0.9	2.1
Мод, сүлжээс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	1.6	0.5	1.8	0.1
Нэхмэл, арьс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	3.3	2.9	2.9	2.8
Өөр газар ангилагдаагүй гар урлалын ажилтан	2.9	1.0	1.5	0.5
Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч	1.8	0.7	0.9	2.7
Хэвлэгч	1.9	1.0	1.1	1.5
Хэвлэлтийг төгс болгох, дэвтэрлэх ажилтан	0.2	1.0	0.0	1.5
Загварчин, үслэг эдлэл, малгай хийгч	0.0	0.4	0.1	0.1
Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин	2.4	1.0	1.0	6.0
Оёдолчин, хатгамалчин, бусад ажилтан	50.9	59.4	52.0	49.2
Тавилгын бүрээс хийгч, бусад холбогдох ажилтан	0.5	0.2	0.0	0.4
Ангийн үс, арьс шир боловсруулагч	0.7	1.1	1.4	2.8
Гуталчин, холбогдох бусад ажилтан	11.4	9.9	11.6	7.8


Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдыг хүйсээр харахад эмэгтэйчүүд нийт ажиллагчдын талаас илүү нь байгаа бол энэ төлөв байдал 2016-2019 онуудад өссөн үзүүлэлттэй байна.

2016 онд нийт дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчдын 68.0 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 2019 онд 72.1 хувь болж 4.1 пунктээр нэмэгдсэн байна.

Мэргэжлээр ялган харахад дүрслэх урлаач, дотоод засал чимэглэлийн дизайнч, дотоод засал чимэглэлийн архитектурч, Эрдэнийн чулуу ба үнэт металлын ажилтан, Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч, Тавилгын бүрээс хийгч, Ангийн үс, арьс шир боловсруулагч мэргэжлээр эрэгтэй хүмүүс илүү ажиллаж байгаа дүр зураг байна.

Зураг 6. Дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчид, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2016 болон 2019 он



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

Зураг 9. Дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчид, хүйсээр, 2016 болон 2019 он

Мэргэжлийн чиглэл	2016			2019		
	Хүйс		Нийт	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	
Архитекторч, дотоод засал чимэглэлийн	333	143	476	303	1174	1477
Бүтээгдэхүүн, хувцасны дизайнерч	68	646	714	564	923	1487
Зурагзүйч, байрзүйч	202	265	467	0	180	180
График, мультимедиа зохиомжийн дизайнерч	614	0	614	1382	129	1511
Дуу хөгжмийн багш	677	572	1249	401	458	859
Соёл, урлагийн багш	35	291	326	410	199	609
Дүрслэх урлаач	1066	579	1645	539	191	730
Дизайнч, дотоод засал чимэглэлийн	81	0	81	154	383	537
Нарийн багаж хийгч, засварчин	360	0	360	384	0	384
Хөгжмийн зэмсэг хийгч, хөглөгч	162	162	324	71	0	71
Эрдэнийн чулуу ба үнэт металлын ажилтан	380	150	530	283	71	354
Ваар, шавар эдлэл хийгч ба холбогдох мэргэжлийн	138	138	276	780	0	780
Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч	457	69	526	0	25	25
Тэмдэг бичигч, гоёл чимэглэлийн будагчин, сийлэгч ба хорын сийлбэрч	0	75	75	539	476	1015
Мод, сүлжээс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	552	0	552	0	192	192
Нэхмэл, арьс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	664	470	1130	157	848	1005
Өөр газар ангилагдаагүй гар урлалын ажилтан	192	785	977	234	308	542
Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч	409	211	620	0	534	533
Хэвлэгч	240	403	643	0	37	37
Хэвлэлтийг төгс болгох, дэвтэрлэх ажилтан	0	74	74	714	1487	2201


Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин	316	488	804	452	17540	17992
Оёдолчин, хатгамалчин, бусад ажилтан	1873	15456	17333	150	0	150
Тавилганы бүрээс хийгч, бусад холбогдох ажилтан	166	0	166	576	438	1015
Ангийн үс, арьс шир боловсруулагч	233	0	233	2101	763	2864
Гуталчин, холбогдох бусад ажилтан	1681	2189	3870	0	0	0
<b>Бүгд</b>	<b>10899</b>	<b>23166</b>	<b>34065</b>	<b>10194</b>	<b>26356</b>	<b>36550</b>

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

Дүрслэх дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь харахад 2016 онд нийт ажиллагчдын 52.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байсан байна. Энэ нь нийт Дүрслэх дизайн урлагийн чиглэлээр ажиллагч 2 хүн тутмын нэг нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байсангы харуулж байна. Харин 36.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч байсан бол 10.1 хувь нь Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байсан байна. Харин 2019 онд Дүрслэх дизайн урлагийн чиглэлээр ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн статусын бүтэц өөрчлөгдөн 50.6 хувь нь цалин хөлстэй ажиллагчид болсон бол Хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1157 (6.5%)-аар буурч 2019 онд 16688 (45.7%) болсон байна.

Мөн дүрслэх дизайн урлагийн мэргэжлийн чиглэлээр ажил олгогчид 2019 онд 1032 (2.8%) болж 2016 оноос 2.1 пунктээр өссөн байгаа бол өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчид 2016 оноос 2019 онд 6.4 пунктээр буурсан байна.

Зураг 7. Дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, 2016 болон 2019 он



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

Хүснэгт 10. Дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчид, мэргэжлийн чиглэл, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, 2016 онд

Бүгд	Хөдөлмөр эрхлэлтийн статус							Бүгд
	Цалин хөлстэй ажиллагч	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Нөхөрлөл, хоршооны гишүүн	Мал аж ахуй эрхлэгч	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч	
	12488	235	17845	0	0	3446	51	34065
Архитекторч, дотоод засал чимэглэлийн	475	0	0	0	0	0	0	475
Бүтээгдэхүүн, хувцасны дизайнч	646	0	68	0	0	0	0	714
Зурагзүйч, байрзүйч	467	0	0	0	0	0	0	467
График, мультимедиа зохиомжийн дизайнч	614	0	0	0	0	0	0	614
Дүрслэх урлаач	460	0	1102	0	0	82	0	1644
Дуу хөгжмийн багш	1249	0	0	0	0	0	0	1249
Соёл, урлагийн багш	326	0	0	0	0	0	0	326
Дизайнч, дотоод засал чимэглэлийн	0	0	81	0	0	0	0	81
Нарийн багаж хийгч, засварчин	128	0	232	0	0	0	0	360
Хөгжмийн зэмсэг хийгч, хөглөгч	162	0	162	0	0	0	0	324
Эрдэнийн чулуу ба үнэт металлын ажилтан	340	0	190	0	0	0	0	530
Ваар, шавар эдлэл хийгч ба холбогдох мэргэжлийн	0	0	138	0	0	138	0	276
Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч	457	0	69	0	0	0	0	526
Тэмдэг бичигч, гоёл чимэглэлийн будагчин, сийлэгч ба хорын сийлбэрч	75	0	0	0	0	0	0	75
Мод, сүлжээс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	188	0	364	0	0	0	0	552
Нэхмэл, арьс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	224	0	680	0	0	230	0	1134
Өөр газар ангилагдаагүй гар урлалын ажилтан	0	57	920	0	0	0	0	977
Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч	429	0	190	0	0	0	0	619
Хэвлэгч	479	0	122	0	0	42	0	643
Хэвлэлтийг төгс болгох, дэвтэрлэх ажилтан	74	0	0	0	0	0	0	74
Загварчин, үслэг эдлэл, малгай хийгч								
Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин	400	0	141	0	0	262	0	803
Оёдолчин, хатгамалчин, бусад ажилтан	4256	178	10609	0	0	2239	51	17333
Тавилганы бүрээс хийгч, бусад холбогдох ажилтан	166	0	0	0	0	0	0	166
Ангийн үс, арьс шир боловсруулагч	158	0	75	0	0	0	0	233
Гуталчин, холбогдох бусад ажилтан	715	0	2702	0	0	453	0	3870

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

Хүснэгт 11. Дүрслэх, дизайн урлагийн мэргэжилтэй ажиллагчид, мэргэжлийн чиглэл, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, 2019 онд


Мэргэжлийн нэр	Хөдөлмөр эрхлэлтийн байдал					Бүгд
	Хувийн бизнесийн үйл ажиллагаа	Өрхийн гишүүдийн болон өрхийн хийж байгаа бизнесийн үйл ажиллагаа	Хэн нэгэнд цалин хөлстэй ажиллагч	Дагалдан дадлагажигч	Хэн нэгэнд ажилладаг өрхийнхөө гишүүнд туслагч	
Бүгд	16688	1032	18491	0	339	36550
Архитекторч, дотоод засал чимэглэлийн	0	0	1477	0	0	1477
Бүтээгдэхүүн, хувцасны дизайнч	257	0	1230	0	0	1487
Зурагзүйч, байрзүйч	0	0	180	0	0	180
График, мультимедиа зохиомжийн дизайнч	449	0	1062	0	0	1511
Дүрслэх урлаач	577	0	154	0	0	731
Дуу хөгжмийн багш	154	0	705	0	0	859
Соёл, урлагийн багш	128	0	481	0	0	609
Дизайнч, дотоод засал чимэглэлийн	0	0	537	0	0	537
Нарийн багаж хийгч, засварчин	0	0	384	0	0	384
Хөгжмийн зэмсэг хийгч, хөглөгч	0	0	71	0	0	71
Эрдэнийн чулуу ба үнэт металлын ажилтан						0
Ваар, шавар эдлэл хийгч ба холбогдох мэргэжлийн						0
Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч	141	71	142	0	0	354
Тэмдэг бичигч, гоёл чимэглэлийн будагчин, сийлэгч ба хорын сийлбэрч	472	0	308	0	0	780
Мод, сүлжээс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	25	0	0	0	0	25
Нэхмэл, арьс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан	1014	0	0	0	0	1014
Өөр газар ангилагдаагүй гар урлалын ажилтан	192	0	0	0	0	192
Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч	0	0	848	0	157	1005
Хэвлэгч	179	0	363	0	0	542
Хэвлэлтийг төгс болгох, дэвтэрлэх ажилтан	0	0	534	0	0	534
Загварчин, үслэг эдлэл, малгай хийгч	37	0	0	0	0	37
Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин	11	11	2179	0	0	2201
Оёдолчин, хатгамалчин, бусад ажилтан	10839	650	6321	0	182	17992
Тавилгын бүрээс хийгч, бусад холбогдох ажилтан	0	0	150	0	0	150
Ангийн үс, арьс шир боловсруулагч	611	0	404	0	0	1015
Гуталчин, холбогдох бусад ажилтан	1602	300	961	0	0	2863

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

## 2.4 Дүрслэх, дизайны мэргэжлээр ажил хайгч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн өнөөгийн байдал


ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2021 оны 07 дугаар сарын 01-ний байдлаар дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажил хайж бүртгүүлсэн ажил хайгч иргэн 329 байсны 187 (56.8%) нь эмэгтэй, 142 (43.2%) нь эрэгтэй ажил хайгчид байна. Насны бүлгийг нь харахад нийт ажил хайгчдын, 129 (39.2%) нь 26-36 насныхан байгаа бол 3 ажил хайгч тутмын нэг нь 37-47 насныхан байна.

Зураг 1. Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажил хайгч иргэд, насны бүлгээр, 2021 оны 07 дугаар сарын байдлаар



Дүрслэх дизайны чиглэлээр ажил хайгч иргэдийн 33.1 хувь нь буюу хамгийн олон нь Улаанбаатар хотод, 12.5 хувь нь Орхон аймагт, 10.3 хувь нь Архангай аймагт байгаа бол хамгийн цөөн буюу 0.6 хувь нь Төв аймагт ажиг хайж байна.


Зураг 1. Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажил хайгч иргэд, аймгаар, 2021 оны 07 дугаар сарын байдлаар



Нийт ажил хайгч иргэдийг мэргэжлээр нь харахад 83 (25.2%) нь ямар нэгэн дизайны 68 (20.7%) нь гутал засварчны, 43 (13.1%) нь нэхий, арьс, үслэг эдлэлийн тоног төхөөрөмжийн инженерийн мэргэжилтэй ажил хайгчид байгаа бол зураачид 17 (5.2%) байна.




Зураг 1. Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажил хайгч иргэд, мэргэжлийн чиглэлээр, хүйсээр, 2021 оны 07 дугаар сарын байдлаар



Дүрслэх дизайн урлагийн чиглэлээр ажил хайгч иргэдийн боловсролын түвшнийг харахад, 137 (41.6%) нь бүрэн дунд боловсролтой иргэд байгаа бол 129 (39.2%) нь Дипломын болон бакалаврын дээд боловсролтой байна. Эндээс харахад бүрэн дунд боловсролтой иргэд ямар нэгэн курс, дамжаагаар мэргэжил эзэмшиж түүнийхээ дагуу ажил хайж байгааг харж байна. нийт дүрслэх, дизайны чиглэлээр мэргэжшсэн ажил хайгчдын 3 хүн тутмын нэг нь диплом болон бакалаврын боловсролтой иргэд байна.

Зураг 1. Дүрслэх, дизайн урлагийн чиглэлээр ажил хайгч иргэд, боловсролын түвшин, хүйсээр, 2021 оны 07 дугаар сарын байдлаар




### Бүлэг 3. Дүрслэх, дизайн урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж буй байдал

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2020-2021 оны хичээлийн жилд 88 байгаагийн 37 (42.1%) нь их сургууль, 45 (51.1%) нь дээд

сургууль, 3 (3.4%) нь коллеж, 3 (3.4%) нь гадаадын их сургуулийн салбар байна. Үүний 65 (73.9 %) нь төрийн бус өмчийн, 20 (22.7 %) нь төрийн өмчийн, 3 (3.4%) нь олон нийтийн/шашны<sup>5</sup> өмчийн сургууль байна. Нийт сургуулийн 79 (89.8%) нь Улаанбаатар хотод, 9 (10.2%) хөдөө, орон нутагт байна.

**Зураг 8. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, ангиллаар, 2017-2021 он**




Эх үүсвэр: Боловсрол, шинжлэх ухааны яам

Нийгэм, эдийн засаг хурдацтай хөгжихийн хэрээр дээд боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгддэг. Улс орны эдийн засгийн урт хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дээд боловсролд хөрөнгө оруулалт хийх нь нэн чухал юм. Тиймээс өөрийн улс оронд гадаадын нэр хүндтэй их, дээд сургуулийн салбарыг бий болгох чиглэлээр анхаарсан бодлогыг хэрэгжүүлэх нь бидний өрсөлдөх чадварт чухал нөлөөтэй.

Манай Улсын Их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 2019-2020 оны хичээлийн жилд 148.4 мянга байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 147.3 мянга болж, өмнөх хичээлийн жилээс 1.1 (0.7%) мянгаар буурсан байна.

**Зураг 9. Нийт суралцагчид, хүйсээр, 2017-2021 он**

<sup>5</sup> Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн маягт 2020 онд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор байгууллагын өмчийн хэлбэрийн ангилалд өөрчлөлт орж, олон нийтийн/шашны гэсэн шинэ ангилал нэмэгдсэн болно.



Эх үүсвэр: Боловсрол, шинжлэх ухааны яам

Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 89.5 (60.7 %) мянга нь эмэгтэй, 57.8 (39.3 %) мянга нь эрэгтэй байна. Эрэгтэй, эмэгтэй оюутнуудын хүйсийн харьцаа 2020-2021 оны хичээлийн жилд 100 эмэгтэй тутамд 65 эрэгтэй ногдож байна.

Нийт суралцагчдыг мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд 35.0 мянга (23.8 %) нь худалдаа, бизнесийн удирдлагын чиглэлд, 19.2 мянга (13.0 %) нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлд, 21.1 мянга (14.3 %) нь анагаах ухааны чиглэлд, 15.5 мянга (10.5%) нь инженерийн чиглэлд, 4.8 мянга (3.3 %) нь Урлагийн төрөл, урлаг судлал чиглэлд тус тус суралцаж байна.

#### Хүснэгт 12. Нийт суралцагчид, мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр, 2016-2021 он


Мэргэжлийн чиглэл	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
<b>Суралцагчид</b>	<b>157 138</b>	<b>155 248</b>	<b>157 625</b>	<b>148 446</b>	<b>147 293</b>
Багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх	22 006	20 810	23 324	22 854	19 162
Хүмүүнлэгийн ухаан	7 099	7 931	8 094	7 148	7 298
Урлагийн төрөл, урлаг судлал	4 702	4 833	5 698	4 761	4 830
Хууль, эрх зүй	8 825	8 903	12 322	11 248	12 776
Нийгмийн шинжлэл	6 853	7 554	5 454	5 983	7 939
Худалдаа, бизнесийн удирдлага	33 134	31 498	30 974	32 615	34 985
Нийтийн мэдээлэл, сэтгүүл зүй	1 346	1 482	1 638	1 546	1 451
Математик, компьютер	4 785	4 182	5 659	5 626	5 926
Үйлчилгээ	6 237	5 643	6 333	6 528	6671
Байгалийн шинжлэл	5 073	5 546	3 649	3 817	2696
Анагаах ухаан	18 540	20 722	22 387	20 903	21095
Инженер	19 010	17 277	16 749	14 282	15451
Архитектур, хот төлөвлөлт	8 247	8 412	6 074	5 596	1731
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур	4 098	3 426	3 528	2 239	944
Бусад мэргэжил	7 183	7 029	5 742	3 300	4338

Эх үүсвэр: Боловсрол, шинжлэх ухааны яам

Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа 205.8 мянган хуулийн этгээдийн 44.6 хувь нь үйл ажиллагаа явуулж, 55.4 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн 59.9 мянга буюу 52.5 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй бол үлдсэн 47.5 хувь нь бусад шалтгаантай байна.

Эдгээр үйл ажиллагаа идэвхтэй явуулж буй хуулийн этгээдийг дүрслэх, дизайны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг салбарын ангиллаар ялган сүүлийн 5 жилээр харьцуулан судаллаа.

Урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт үйл ажиллагаа явуулдаг бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага 2016 онд нийт 1037 байсан бол 2021 оны эхний улиралд 1199 болж, 162 (15.6%)-оор өссөн байна. 2016-2020 оны хооронд урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт үйл ажиллагаа явуулдаг бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 203 (19.6%)-аар өссөн байна.

Зураг. Үйл ажиллагаа явуулдаг бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, 2016-2021




Үйл ажиллагаа явуулдаг бизнес регистрийн санд бүртгэлтэй Дүрслэх, дизайны чиглэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2016 онд 1233 байсан бол 2020 онд 1534 болж өсөөд, 2021 оны эхний улиралд 1448 болж буурсан дүр зураг харагдаж байна.

Үйл ажиллагаа явуулдаг бизнес регистрийн санд бүртгэлтэй Дүрслэх, дизайны чиглэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагыг салбараар нь нарийвчлан харахад, 2021 оны эхний улирлын байдлаар нийт байгууллагын 563 (38.9%) нь Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа, 486 (33.6%) нь Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл, 162 (11.2%) нь Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл, 100 (6.9%) нь гутал үйлдвэрлэл, 73 (5.0%) нь Номын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа, 61 (4.2%) нь Хувцаснаас бусад нэхмэл болон сүлжмэл эдлэл үйлдвэрлэл, 3 (0.2%) нь Хивс, хивсэнцэр үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын тоо 2016 онд 80 байсан бол жил бүр тогтмол өссөөр 2021 оны 1-р улирлын байдлаар 162 болж, 82-оор буюу 2 дахин, Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын тоо 2016 онд 476 байсан бол

2021 оны 1-р улиралд 563 болж, 87 (18.3%)-оор, Гутал үйлдвэрлэлийн байгууллагууд 2016 онд 81 байсан бол 2021 оны 1-р улиралд 100 болж, 19 (23.5%)-өөр тус тус өссөн нь үйл ажиллагаа нь хамгийн их тэлж байгаа салбарууд гэдгийг харуулж байна.

Зураг. Үйл ажиллагаа явуулдаг бизнес регистрийн санд бүртгэлтэй Дүрслэх, дизайны чиглэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, Дүнд эзлэх хувь, 2016-2021



Хүснэгт . Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, салбараар, 2016-2021 он


Салбар	2016	2017	2018	2019	2020	2021-I
<b>УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ НААДАМ-НИЙТ</b>	<b>1 037</b>	<b>1 108</b>	<b>1 148</b>	<b>1 225</b>	<b>1 240</b>	<b>1 199</b>
9000. Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	<b>476</b>	490	511	526	515	563
<b>МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО-НИЙТ</b>	<b>1 604</b>	<b>1 796</b>	<b>2 006</b>	<b>1 974</b>	<b>2 014</b>	<b>2 111</b>
5811. Номын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	<b>83</b>	100	104	81	71	73
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ-НИЙТ</b>	<b>4 857</b>	<b>5 290</b>	<b>5 696</b>	<b>6 360</b>	<b>6 355</b>	<b>5 726</b>
1392. Хувцаснаас бусад нэхмэл болон сүлжмэл эдлэл үйлдвэрлэл	<b>62</b>	64	63	71	76	61
1393. Хивс, хивсэнцэр үйлдвэрлэл	<b>4</b>	6	6	8	7	3
<b>14. Хувцас үйлдвэрлэл-нийт</b>	<b>553</b>	<b>608</b>	<b>645</b>	<b>772</b>	<b>790</b>	<b>683</b>
1410. Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	<b>447</b>	480	493	581	562	486
1430. Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл	<b>80</b>	101	119	154	191	162
1520. Гутал үйлдвэрлэл	<b>81</b>	87	95	114	112	100

Үйл ажиллагаа явуулдаг бизнес регистрийн санд бүртгэлтэй Дүрслэх, дизайны чиглэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэрээр нь харахад, 2016 онд хувийн өмчийн байгууллага 848 (68.8%) байсан бол 2021-I-р улиралд 1059 болж, 4.4 пунктээр нэмэгдсэн байна. Харин нийт байгууллагын тоонд төрийн өмчийн байгууллагын эзлэх хувь 2016 - 2021 оны эхний улиралд 4.2 пунктээр, гадаадын улсын байгууллагын эзлэх хувь 0.2 пунктээр тус тус буурсан байна. Эндээс харахад бизнес регистрийн санд бүртгэлтэй Дүрслэх, дизайны чиглэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй хувийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын тоо өссөөр байгааг харж болно.

Хүснэгт . Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, салбараар, 2016-2021 он

Салбар	2016			2021-I		
	Төрийн болон орон нутгийн өмчийн	Хувийн	Гадаад улсын	Төрийн болон орон нутгийн өмчийн	Хувийн	Гадаад улсын
9000. Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	375	101	0	380	181	2
5811. Номын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	0	83	0	-	73	-
1392. Хувцаснаас бусад нэхмэл болон сүлжмэл эдлэл үйлдвэрлэл	0	61	1	-	60	1
1393. Хивс, хивсэнцэр үйлдвэрлэл	0	4	0	-	3	-
1410. Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	2	442	3	3	481	2
1430. Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл	1	78	1	-	162	-
1520. Гутал үйлдвэрлэл	1	79	1	1	99	-
НИЙТ	379	848	6	384	1059	5

Зураг. Үйл ажиллагаа явуулдаг бизнес регистрийн санд бүртгэлтэй дүрслэх, дизайны чиглэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, өмчийн хэлбэрээр, дүнд эзлэх хувь, 2016, 2021 харьцуулалт



**Бүлэг7. Дүрслэх, дизайн урлагийн эрх зүйн орчинд хийсэн шинжилгээ**



Соёлын тухай хуулиудыг үндэслэн салбарын эрх зүй, зохион байгуулалтын асуудлуудыг зохицуулах, сайжруулах чиглэлээр соёлын салбарт зарим эрх зүйн баримт бичиг /тогтоол, захирамж, тушаал, журам, дүрэм, стандарт/-ийг батлан хэрэгжүүлсээр ирсэн байна.

Онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд олгох мөнгөн шагналын хэмжээг, “Олон улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагийн жагсаалт”-ыг, “Олон улсын хэмжээнд зохиогддог өсвөрийн уран бүтээлчдийн соёл, урлагийн их наадам, уралдааны жагсаалт”-ыг тус тус шинэчлэн баталсан байна. Кино театр, дүрслэх урлаг, номын яармаг, утга зохиолын төрлөөр шалгарсан уран бүтээлчдэд олгох мөнгөн шагнал нь “А” ангилалын дүрслэх урлагийн бүтээлийн тэргүүн шагнал 65 сая, “Б” ангилалын дүрслэх урлагийн бүтээлийн тэргүүн шагнал 24 сая төгрөг байхаар заасан байна.

Монгол улсын “Соёлын тухай” хуулийн /1996.4.11/ 6-р бүлгийн 21-р зүйлийн 9-д “хөгжмийн том хэлбэрийн болон дүрслэх урлаг, кино, ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авч байна. Шилдэг бүтээл шалгаруулан худалдаж авах журмыг Засгийн газар тогтооно” /2002. 6.20-ны өдрийн хуулиар нэмсэн/ гэж заасныг үндэслэн Монгол улсын засгийн газар /2006.5.24.115/ “Хөгжмийн том хэлбэрийн бүтээлийг улсын санд худалдан авах журам”, “Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журам”-ыг тус тус баталжээ/ шинэчилсэн найруулгаар хуулийн заалт өөрчлөгдсөн/. Хөгжмийн том хэлбэрийн болон дүрслэх урлаг, ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авахад зориулж тус бүр 50 сая, нийт 150 сая төгрөгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэх” -ээр энэхүү журамд заажээ. Соёлын тухай /Шинэчилсэн найруулга/ **9.1.Соёлын үйл ажиллагааг дараах чиглэлээр** явуулна: 9.1.7.дүрслэх урлаг, уран сайхны гэрэл зураг, гар урлал, хэрэглээний урлагийн бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа; 9.1.10.дизайн, архитектурын бүтээл туурвихтай холбоотой үйл ажиллагаа гэж заасан. Мөн тус хуулийн **32 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагааны санхүүжил 32.7.**Хөгжим, дүрслэх урлаг, утга зохиолын шилдэг бүтээлийг улсын санд худалдан авна. Шилдэг бүтээл шалгаруулах, худалдан авах, хадгалах, ашиглах журмыг Засгийн газар батална. 32.8.Үндэсний болон сонгодог урлагийн бүтээл, хүүхдэд зориулсан уран бүтээлд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална гэж тус тус баталжээ.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Төрөөс баримтлаж буй дүрслэх, дизайн урлагийн талаарх тогтоол, шийдвэр нь тухайн нийгэм цаг үедээ хэрэгцээтэй байсан боловч өнөөгийн нийгмийн хувьсал, өөрчлөлт, дэлхий нийтийн чиг хандлагатай соёл, урлагийн үйл ажиллагааг уялдуулахад зайлшгүй шинэчлэн боловсруулах, шинээр батлуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Дэлхийн улс орнуудад бүтээлч үйл ажиллагаа нь хурдацтай хөгжиж буй салбар бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээ, график дизайн, хувцасны загварыг багтаасан байдаг боловч бидний хувьд дизайн нь хувь хүнд чиглэсэн, бүтээлч асуудлыг шийдвэрлэх үйл явцтай улам бүр холбоотой болж байна. Дүрслэх, дизайн урлаг нь нийгмийн амьдралд чухал байр суурийг эзэлдэг бөгөөд нийгмийн ухамсарт бодит байдлыг дүрслэн харуулах, нийтийн ёс суртахууныг төлөвшүүлэх өвөрмөц чанараараа оюун санааны, соёл, нийгмийн болон эдийн засгийн салбарт шууд нөлөөлдөг нийгмийн соёлд зайлшгүй шаардлагатай салбар юм.

XX зууны Монголын нийгмийн амьдралд гарсан томоохон өөрчлөлтүүд түүнийг дагасан боловсролын салбарын хөгжил хөдөлгөөн нь нэгэнт түүхийн гэрч болон үлджээ.

2021 оны байдлаар дүрслэх урлагийн салбарын боловсон хүчнийг бэлтгэхэд сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд, ерөнхий боловсролын дунд сургуулиуд, тусгай мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй төрийн өмчийн дунд сургууль – 1 /Ражив Гандийн нэрэмжит үйлдвэрлэл-урлалын сургууль/, төрийн өмчийн их сургууль – 4 /СУИС-ДУС “Дүрслэх урлагийн академи” дээд сургууль, МУИС-МХСС-АУСТ, МУБИС-ДУТС, ШУТИС-ҮТДС/, төрийн бус өмчийн их сургууль -1 /ИЗИС/, төрийн өмчийн дээд сургууль – 3 /Бурхан шашны дээд сургууль, Зохиомж дээд сургууль, Урлах эрдэм дээд сургууль/, төрийн бус өмчийн коллеж – 1 /Дизайн урлагийн коллеж “Барилга архитектурын” корпораци/, бусад хувийн сургууль -1 /Анима/ өөр өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж байна.

Дүрслэх, дизайны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн төрийн дэмжлэг үзүүлэх бодлого нь дизайныг бүх салбарын бизнес эрхлэхэд ашиглах эрчмийг нэмэгдүүлэх, түүнчлэн бүтээлч эдийн засгийн чухал салбар болох дизайны хөгжлийг дэмжихэд оршино. Монгол улсын их хурал, Засгийн газраас уран бүтээлийн чанар, тоог нэмэгдүүлэх, билэг авьяасыг үнэлэх, уран бүтээлчдэд шагнаж, урамшуулах, шилдэг

бүтээлийг төсвийн хөрөнгөөр улсын санд худалдан авах зэрэг тодорхой хэдэн журмуудыг мөрдөж байна.

Монгол улсын тухайд дүрслэх, дизайн урлагийн хувь хүн, нийгэм эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр, ач холбогдлын талаарх ойлголт бүрэн төлөвшөөгүй, төрөөс дэмжин хөгжүүлэх бодлого, дэмжлэг хомс, олон нийтийн соёлын хэрэгцээ үнэлэмжийн түвшин доогуур, салбар нь орчин цагтайгаа нийлүүлэн хөгжиж эхэлж байгаа учир энэ салбарыг хөгжүүлэх талаар төрийн баримтад тулгуурласан бодлогуудыг томьёолж, тэдгээрийн нөлөөг хэмжиж, үнэлж дүгнэхэд бодит мэдээлэл судалгаа зайлшгүй шаардлагатай.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжснээр бүтээлийн үнэ, худалдаа түүнд хандах эрхзүйн орчин цогцоороо өөрчлөгдсөн байна. Дүрслэх урлагийн ууган байгууллага ч энэ л замаар нийгэм дэх байр сууриа хадгалж байна. Дүрслэх урлагийн уран бүтээлчдийн нэгдсэн томоохон байгууллага болох Монголын Урчуудын эвлэл нь 70 жилийн түүхтэй, эгнээндээ 700 гаруй гишүүнтэй дотоод гадаадад бүтээлчдийнхээ үзэсгэлэнг жил бүр уламжлал болгон хэд хэдэн удаа гаргаж бүтээлүүдээс нь ч цуглуулагчдад худалдаж зураачдынхаа бүтээл хийх үзэсгэлэн гаргах олон нийтэд сурталчлах боломжийг бүрдүүлж иржээ.

Цаашид уран зураг, гар урлал, дизайн урлагийн хүрээнд тусгайлсан бодлого боловсруулах, хүний нөөцийн талаарх хөтөлбөр хэрэгжүүлэх, стандартууд бий болгох, удирдлага зохион байгуулалтаар хангах хэрэгцээ шаардлага байна.

#### Үүний хүрээнд:

1. Салбарын хүрээнд эрх зүйн шинжилгээ хийгдэж, цаашид мөрдөгдөх эрх зүйн баримт бичгүүдийн хувилбарыг боловсруулах;
2. Салбарын хөгжилд нэн шаардлагатай нарийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, эрдэмтэн, судлаач нарын оролцоог нэмэгдүүлэх;
3. Төрөөс дүрслэх, дизайны урлагийн оюутан сурагчдад зориулсан тэтгэлэгт хөтөлбөр зарлах;
4. Хөдөрмөр эрхлэлтийн мөшгих судалгааг хийх;
5. Суралцагчын дунд түүвэр судалгаа хийж эрэлт хэрэгцээг тодорхойлох;

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

- ҮСХ, Ажиллах хүчний судалгааны тайлан
- Монгол Улсын Соёлын тухай хууль
- ХНХЯ-ны Техник, мэргэжлийн боловсролын статистикийн үзүүлэлтийн тайлан

**ХАВСРАЛТ**

Хүснэгт 3. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, дүнд эзлэх хувь, 2016-2021

Салбар	2016	2017	2018	2019	2021-I
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	30.4	28.8	26.7	25.3	28.7
Уул уурхай, олборлолт	3.3	4.2	4.6	5.1	4.6
Боловсруулах үйлдвэрлэл	7.5	7.5	8.0	7.9	7.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.4	1.4	1.3	1.7	1.6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.5	0.4	0.5	0.9	1.1
Барилга	6.2	5.7	6.1	6.0	5.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	15.0	16.5	16.9	14.0	13.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.7	5.9	5.9	5.3	4.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.8	2.9	3.0	3.2	3.3
Мэдээлэл, холбоо	1.6	1.2	1.1	1.1	1.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.9	1.9	2.1	2.1	2.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.1	0.0	0.1	0.1	0.1

Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.1	1.0	1.2	1.6	0.9
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.3	1.7	1.5	1.8	2.1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	6.5	6.6	6.1	7.5	7.2
Боловсрол	8.3	8.0	7.9	8.4	8.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3.6	3.2	3.9	3.9	4.3
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.9	0.8	1.1	1.6	0.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.7	1.8	1.9	2.1	2.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.1	0.2	0.1	0.3	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.1	0.1	0.2	0.2	0.2
	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зураг 4. Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчид, насны бүлэг, хүйсээр, 2016-2021

Насны бүлэг	Хүйс	2016	2017	2018	2019	2021-I
Улсын дүн	Бүгд	10,090.	10,104.	13,835.	17,999.	8,779.
Улсын дүн	Эрэгтэй	4,995.	5,503.	6,909.	7,102.	5,861.
Улсын дүн	Эмэгтэй	5,095.	4,602.	6,925.	10,897.	2,918.
15-19	Бүгд	74.	57.	270.	400.	668.
15-19	Эрэгтэй	0.	57.	123.	154.	668.
15-19	Эмэгтэй	74.	0.	147.	246.	0.
20-24	Бүгд	1,077.	1,469.	1,548.	511.	41.
20-24	Эрэгтэй	502.	781.	629.	511.	0.
20-24	Эмэгтэй	575.	689.	919.	0.	41.
25-29	Бүгд	2,156.	1,586.	2,430.	1,755.	2,107.
25-29	Эрэгтэй	983.	983.	1,273.	277.	1,953.
25-29	Эмэгтэй	1,173.	603.	1,157.	1,478.	154.
30-34	Бүгд	1,371.	1,548.	1,635.	3,470.	550.
30-34	Эрэгтэй	535.	965.	698.	1,009.	253.
30-34	Эмэгтэй	837.	584.	937.	2,461.	296.

35-39	Бүгд	1,953.	1,377.	1,816.	2,729.	1,892.
35-39	Эрэгтэй	1,111.	731.	1,104.	816.	0.
35-39	Эмэгтэй	842.	646.	711.	1,913.	1,892.
40-44	Бүгд	1,654.	1,429.	1,842.	3,202.	809.
40-44	Эрэгтэй	988.	553.	878.	1,658.	539.
40-44	Эмэгтэй	666.	877.	965.	1,544.	270.
45-49	Бүгд	659.	1,118.	1,887.	2,655.	520.
45-49	Эрэгтэй	309.	326.	980.	889.	315.
45-49	Эмэгтэй	350.	791.	907.	1,766.	206.
50-54	Бүгд	811.	765.	1,433.	1,033.	2,132.
50-54	Эрэгтэй	333.	437.	623.	125.	2,132.
50-54	Эмэгтэй	478.	328.	810.	908.	0.
55-59	Бүгд	230.	648.	844.	695.	60.
55-59	Эрэгтэй	177.	648.	472.	684.	0.
55-59	Эмэгтэй	53.	0.	372.	10.	60.
60-64	Бүгд	106.	22.	65.	1,235.	0.
60-64	Эрэгтэй	57.	22.	65.	663.	0.
60-64	Эмэгтэй	49.	0.	0.	571.	0.
65-69	Бүгд	0.	84.	65.	0.	0.
65-69	Эрэгтэй	0.	0.	65.	0.	0.
65-69	Эмэгтэй	0.	84.	0.	0.	0.
70+	Бүгд	0.	0.	0.	315.	0.
70+	Эрэгтэй	0.	0.	0.	315.	0.
70+	Эмэгтэй	0.	0.	0.	0.	0.

Хүснэгт 3. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, дүнд эзлэх хувь, 2016-2021

Салбар	2016	2017	2018	2019	2021 -I
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	30.4	28.8	26.7	25.3	28.7

Уул уурхай, олборлолт	3.3	4.2	4.6	5.1	4.6
Боловсруулах үйлдвэрлэл	7.5	7.5	8.0	7.9	7.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.4	1.4	1.3	1.7	1.6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.5	0.4	0.5	0.9	1.1
Барилга	6.2	5.7	6.1	6.0	5.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	15.0	16.5	16.9	14.0	13.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.7	5.9	5.9	5.3	4.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.8	2.9	3.0	3.2	3.3
Мэдээлэл, холбоо	1.6	1.2	1.1	1.1	1.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.9	1.9	2.1	2.1	2.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.1	0.0	0.1	0.1	0.1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.1	1.0	1.2	1.6	0.9
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.3	1.7	1.5	1.8	2.1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	6.5	6.6	6.1	7.5	7.2
Боловсрол	8.3	8.0	7.9	8.4	8.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3.6	3.2	3.9	3.9	4.3
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.9	0.8	1.1	1.6	0.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.7	1.8	1.9	2.1	2.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.1	0.2	0.1	0.3	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.1	0.1	0.2	0.2	0.2
	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зураг 4. Урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбарт ажиллагчид, насны бүлэг, хүйсээр, 2016-2021

Насны бүлэг	Хүйс	2016	2017	2018	2019	2021-I
Улсын дүн	Бүгд	10,090.	10,104.	13,835.	17,999.	8,779.



Улсын дүн	Эрэгтэй	4,995.	5,503.	6,909.	7,102.	5,861.
Улсын дүн	Эмэгтэй	5,095.	4,602.	6,925.	10,897.	2,918.
15-19	Бүгд	74.	57.	270.	400.	668.
15-19	Эрэгтэй	0.	57.	123.	154.	668.
15-19	Эмэгтэй	74.	0.	147.	246.	0.
20-24	Бүгд	1,077.	1,469.	1,548.	511.	41.
20-24	Эрэгтэй	502.	781.	629.	511.	0.
20-24	Эмэгтэй	575.	689.	919.	0.	41.
25-29	Бүгд	2,156.	1,586.	2,430.	1,755.	2,107.
25-29	Эрэгтэй	983.	983.	1,273.	277.	1,953.
25-29	Эмэгтэй	1,173.	603.	1,157.	1,478.	154.
30-34	Бүгд	1,371.	1,548.	1,635.	3,470.	550.
30-34	Эрэгтэй	535.	965.	698.	1,009.	253.
30-34	Эмэгтэй	837.	584.	937.	2,461.	296.
35-39	Бүгд	1,953.	1,377.	1,816.	2,729.	1,892.
35-39	Эрэгтэй	1,111.	731.	1,104.	816.	0.
35-39	Эмэгтэй	842.	646.	711.	1,913.	1,892.
40-44	Бүгд	1,654.	1,429.	1,842.	3,202.	809.
40-44	Эрэгтэй	988.	553.	878.	1,658.	539.
40-44	Эмэгтэй	666.	877.	965.	1,544.	270.
45-49	Бүгд	659.	1,118.	1,887.	2,655.	520.
45-49	Эрэгтэй	309.	326.	980.	889.	315.
45-49	Эмэгтэй	350.	791.	907.	1,766.	206.
50-54	Бүгд	811.	765.	1,433.	1,033.	2,132.
50-54	Эрэгтэй	333.	437.	623.	125.	2,132.
50-54	Эмэгтэй	478.	328.	810.	908.	0.
55-59	Бүгд	230.	648.	844.	695.	60.
55-59	Эрэгтэй	177.	648.	472.	684.	0.
55-59	Эмэгтэй	53.	0.	372.	10.	60.
60-64	Бүгд	106.	22.	65.	1,235.	0.

60-64	Эрэгтэй	57.	22.	65.	663.	0.
60-64	Эмэгтэй	49.	0.	0.	571.	0.
65-69	Бүгд	0.	84.	65.	0.	0.
65-69	Эрэгтэй	0.	0.	65.	0.	0.
65-69	Эмэгтэй	0.	84.	0.	0.	0.
70+	Бүгд	0.	0.	0.	315.	0.
70+	Эрэгтэй	0.	0.	0.	315.	0.
70+	Эмэгтэй	0.	0.	0.	0.	0.

### **“ДҮРСЛЭХ УРЛАГИЙН АКАДЕМИ” ДЭЭД СУРГУУЛИЙН ТОВЧ НАМТАР**

Монгол Улсын дүрслэх урлагийн боловсрол үүсэн хөгжсөн буюу Дүрслэх урлагийн сургуулиар мэргэжилтэн уран бүтээлч бэлтгэж эхэлснээс хойш 75 жил болжээ.

1989 оны 5-р сарын эцсээр хуучнаар Дүрслэх урлагийн сургууль нь Гурван Яам буюу Шүүх, Хөнгөн хүнсний, Тээврийн зэрэг яамдын байрлаж байсан одоогийн энэ байранд Засгийн газрын тогтоолыг үндэслэн протоколоор өрөөнүүдийг дугаарын дагуу хүлээж авсан юм. 1990 оноос Монгол орон дүрслэх урлагийн дээд боловсролын хэрэгцээгээ ЗХУ болон бусад гадаад орнуудад бэлтгэн хангаж байсан нь алга болж өөрсдийнхөө хэрэгцээг өөрсдийнхөө бололцоогоор хангах болсноор Монголын нийгэмд шинэ эрэлт хэрэгцээг бий болгож Дүрслэх урлагийн сургуулийг үндсэн үйл ажиллагаагаа өөрчилж бүр илүү үр ашигтай, нийт үндэстэнийхээ ашиг сонирхлыг хувь иргэний сонирхолтой зөв хослуулан сургалт явуулж нийгмээс урлахуй ухааны салбар дахь дээд боловсролын хэрэгцээг хангаж ажиллах шаардлагыг бий болгов.

Иймээс Дүрслэх урлагийн дунд сургууль нь 1992 оноос Дүрслэх урлагийн коллеж, 1994 оноос Урлагийн үндэсний их сургуулийн Урлахуй ухааны эрдэм шинжилгээний төв болж сургалтыг дунд ба бакалаврын түвшинд бэлтгэж эхэлсэн юм. Цаашид орчин үеийн нийгмийн хөгжилтэй уялдуулан сургалтыг судалгааны ажилтай хослуулах, шинжлэх ухааны ажлыг сургалттай зэрэгцүүлэн тавих зүй ёсны хэрэгцээ шаардлага урган гарсан байна. Монгол улсын Гэгээрлийн Яамны Сайдын тушаалаар 1998 онд тус сургуулийг бие даалгаж Дүрслэх урлагийн дээд сургууль болгожээ.

“Дүрслэх урлагийн академи” дээд сургуулт нь өөрийн түүхэндээ нийт 2131 хүн 16 мэргэжлээр төгсгөж олон арван тэргүүний уран бүтээлчид төрүүлэн гаргаснаас

Ц.Гомбосүрэн, Д.Амгалан нар Ардын зураач, С.Дондог, О.Мягмар, Г.Цэрэндондог, П.Цогзол, Ч.Батмөнх, Д.Дамдимаа, Д.Цэрэнпил, Б.Сүмхүү, Б.Чогсом, Ч.Дашзэвэг нар Урлагийн гавьяат зүтгэлтэн, Д.Сандагдорж, Л.Болд, Г.Пүрэвбат нар Соёлын гавьяат зүтгэлтэн, дэлхийн самбо бөхийн аварга Х.Баттулга спортын гавьяат мастер, Д.Амгалан, Б.Пүрэвсүх, Ц.Амгалан, До.Болд, Ц.Цэгмид Л.Ганхуяг нар Төрийн соёрхол зэрэг алдар цол хүртжээ.

Төр засгаас зураач, урчуудын цалинг нэмэгдүүлэх, уран бүтээл туурвих цаг, нөхцөл боломж, материалаар хангах талаар анхаарч холбогдох тогтоол, тушаал гаргаж байжээ. Тухайлбал, МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1954.8.16-ны 42/243 тогтоолоор "...урлагийн хэрэг эрхлэх хорооны захиалгын дагуу зураач урчуудыг болон дүрслэх урлагийн сургуулийг шаардагдах материалаар хангахын тулд гадаад худалдааны газраар дамжуулан цаг тухайд нь уг материалыг захиалж байх"-аар шийдвэрлэсэн байна.

БНМАУ-ын СнЗ-ийн 136-р тогтоолоор<sup>6</sup> "...урлагийн газруудын уран бүтээлчдийн мэргэжил, чадвар дээшилж байгаатай холбогдуулан найруулагч, зураач, хормейстр, балетмейстр, хөгжмийн удирдагч нар жилд 4 уран бүтээл туурвих нормыг тогтоож, дээрх нормоос илүү шинэ бүтээл хийсэн найруулагч, зураач, багш нарт болон уран бүтээлдээ онц гарамгай амжилт гаргаж шинэ зүйлүүдийг туурвисан урлагийн ажилтан нарт уул бүтээлийн цалин, шагнал олгох"<sup>7</sup>, урлагийн ажилтны мэргэжил, уран бүтээлийн чанарыг харгалзахгүйгээр зөвхөн үнэмлэхийн зэргийг баримтлан цалин олгож байгаа байдлыг өөрчлөх<sup>8</sup> гэсэн шийдвэрүүд тусгагдаж байжээ. Тухайн үед мөрдөгдөж байсан цалингийн систем, шагнал урамшуулал нь урлагийн ажилтны идэвхи сонирхлыг өрнүүлж, шинэ бүтээлчид төрөн гарч, урлан бүтээх, мэргэжил чадвараа дээшлүүлэхэд чиглэгдсэн бодлого байв. МХЗЭ, МУЭ-ийн хорооны хамтарсан хурлаас "Шилдэг бүтээлд олгох шагнал бий болгох тухай" тогтоол (1981.03.03 дугаар 9/21) гарчээ.

Тус сургууль зөвхөн уран бүтээлч бэлтгээд зогсохгүй шинжлэх ухааны судалгаа шинжилгээ явуулах, багш нар нь ганцхан уран бүтээлч байхаар барахгүй онолч, судлаач байх шаардлага тулгарч сургуулийн багш нар эрдмийн ажил эрхэлж үндэснийхээ урлагийг сайтар судлан шинжлэх, өв уламжлалыг олон улсын тэргүүний арга барил, технологитой хослуулах, сургуулийн сургалтыг олон улсын жишигт хүргэхээр зорилт тавин ажиллаж байна. Дүрслэх урлагийн дээд сургууль нь Захирлын ажлын алба, сургалтын алба, Санхүү эдийн засаг, хангамжийн алба, хоёр салбар, таван тэнхим гэсэн үндсэн нэгжүүдээс бүрдэж байгаа бөгөөд жилдээ 400 гаруй оюутан өдрөөр хичээллэж 60 орчим ажилтан, уран бүтээлч эрдэмтэн багш нарын бүрэлдэхүүнтэй орчин үеийн урлахуй ухааны сургалт уран бүтээл, эрдэм шинжилгээний үндэсний томоохон төв болж хөгжиж 2002 онд тус сургууль 100%

<sup>6</sup> БНМАУ-ын СнЗ-ийн 1956 оны 3дугаар сарын 24-ний 136-р тогтоол

<sup>7</sup> МАХН-аас урлаг, утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэрүүд (1921-1966), УБ.1967. 230-231-р тал

<sup>8</sup> Мөн тэнд. 241-р тал

магадлан итгэмжлэгдсэн юм.

Тус сургууль байгуулагдаад 75 жилийн хугацаанд тус сургуульд ажиллаж түүнийг хөгжүүлэх талаар манай тэргүүний уран бүтээлч сэхээтнүүд, боловсон хүчнүүдийн хүчин чармайлтын үр дүнд одоо тус сургууль 2 салбартай 5 тэнхимтэй, 420 орчим оюутантай, 60-аад нэрт уран бүтээлч процессор багштайгаар дипломын болон бакалаврын боловсрол олгох, нарийн мэргэжил эзэмшүүлэх сургалт эрхэлж байна. Тус сургуулийн гол үнэт зүйлс бол дэлхийн чанартай олон улсын үзэсгэлэнгүүдэд амжилттай оролцон эх орныхоо нэрийг өндөрт өргөж байдагт оршино.

1945 онд үүсгэн байгуулагдсан тус сургууль нь улсын дүрслэх урлагийн боловсрол, тус сургуулийн хувьд нэгэн жаран дамнасан түүхэн замнал бөгөөд сургууль байгуулагдаж байсан тухайн цаг үе, нөхцлийг бодоход удирдлага зохион байгуулалт, багшлах боловсон хүчний хувьд ч, материаллаг баазын хувьд ч, нэр төрийн хувьд ч, нийгэмд эзлэх байр суурийн хувьд ч гэсэн бүрэн хөл дээрээ зогсож тодорхой өөрийн орон зайг эзлэсэн сургалт-уран бүтээл-эрдэм шинжилгээний бие даасан төв болж улс орныхоо дүрслэх урлагийн ирээдүйн хөгжлийг болон хөгжлийн бодлогыг тодорхойлогч бие бүрэлдэхүүн бүхий тодорхой хүчин болсон юм.


## **ШУТИС-ИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН ДИЗАЙНЫ САЛБАРЫН ТОВЧ ТҮҮХ**

Монгол улс дээд мэргэжилтэй дизайнер бэлтгэж эхэлсэн ууган боловсролын байгууллагын нэг нь ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Дизайны салбар юм. Тус салбар өдгөө 32 багштай, бакалавр, магистр, докторын түвшний сургалт явуулдаг 900 орчим оюутантай манай улсын дизайны боловсролын томоохон нэгж юм. Сургалт явуулж ирсэн түүхэн хугацаандаа “Үйлдвэрлэлийн дизайн”, “Хувцасны дизайн”, “Нэхмэлийн дизайн”, “Компьютер график дизайн”, “Хэвлэлийн график дизайн”, “Мебель модон эдлэлийн дизайн” мэргэжлүүдээр дээд болосролтой дизайнеруудыг бэлтгэж байгаад БШУ-ны Сайдын 2014.04.28-ны өдрийн А/174 тоот тушаалын хавсралт “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага” дагуу 2014 оноос “Үйлдвэрлэлийн дизайн”, “Интерьер дизайн”, “Хувцасны дизайн”, “График дизайн” хөтөлбөрүүдээр сургалт явуулж байна.

Дизайны салбарын зорилго нь үр дүнд суурилсан мэдлэгтэй, мэдлэгийг баялаг болгох чадамжтай төгсөгчийг бэлтгэхийн тулд профессор багш нарыг судалгаа-уран бүтээл-багшлах арга зүйн нэгдмэл хэлбэрээр чадавхижуулж, эрчимтэй, бүтээлч тасралтгүй үйл ажиллагааг зорилго болгоно. Дээрх зорилгоо биелүүлэхийн тулд Салбарын үйл ажиллагааг доорх 5 бүлэгт хуваан төлөлөж байна.

1. Бодлого, төлөвлөлт, менежмент буюу санхүүжилт, хөрөнгө, оруулалтын хувьд,

2. Институцийн чадавх буюу хүний (багшийн) хөгжлийн хувьд,
3. Итгэл үнэмшил соёл буюу ёс зүй, хамтын ажиллагааны хувьд,
4. Байгууллагын дэд бүтэц буюу сургуулийн барилга, дата, сүлжээний хувьд,
5. Хууль эрх зүйн тогтолцоо буюу дүрэм журам стандартын хувьд төлөвлөж байна.



### ШУТИС-ийн ҮТС-ийн Дизайны салбарын хөгжлийн үзэл баримтлал

**Үйлдвэрлэлийн дизайн.** Монгол улсад дээд боловсролтой үйлдвэрлэлийн дизайны мэргэжилтэн бэлтгэх түүх 1994-1995 оны хичээлийн жилээс эхэлжээ. Тухайн үеийн ТИС-ийн БИС-ийн ИЗЗ тэнхимийн дэргэд дизайны салбар байгуулагдаж ТИС-ийн бүтцийн өөрчлөлтөөр 1996-0101-ээс Инженерийн суурь боловсролын сургуулийн харьяанд тэнхимийн хамт шилжиж 1998-10-15-аас бие даасан “Үйлдвэрлэлийн дизайн” тэнхим болсон. Тус тэнхим Эдэлхүүний дизайн, Интерьер дизайн, Сав баглаа боодлын дизайн гэсэн 3 мэргэжлийн чиглэлээр дизайнер бэлтгэж иржээ. Тус тэнхимийн үйл ажиллагаа нь үндэсний үйлдвэрлэлийн дизайны сургалт, судалгаа, практикийн асуудлыг шийдвэрлэхэд тэргүүлэх үүрэгтэй ажиллаж байгаа бөгөөд өөрийн эрхэм зорилгоо биелүүлэхэд тус тэнхимийн цаашдын үйл ажиллагаа чиглэгдэнэ. 2001 онд ҮТДС-д дизайны мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний өөрчлөлт хийгдэж, Сав баглаа боодлын дизайн мэргэжлийн хөтөлбөрийг шинэчлэн “Хэвлэлийн график дизайн”, Эдэлхүүний дизайн мэргэжлийг “Мебель, модон эдлэлийн дизайн” мэргэжлүүд болгон өөрчилж Үйлдвэрлэлийн дизайн нэрээр “Интерьер дизайн” мэргэжлийн элсэлт авч сургалт явуулжээ. “Мебель модон эдлэлийн дизайн”, “Үйлдвэрлэлийн дизайн” мэргэжлүүдийн бакалаврын сургалтын төлөвлөгөөг 2003, 2007 онуудад шинэчлэн баталж байсан юм. Үүний дараа тухайн мэргэжлийн хөтөлбөрүүдийг 2 удаа шинэчлэн сайжруулснаас эхний удаа 2011 онд

доор дурьдсан мэргэжлүүдийн бакалаврын түвшний боловсролын агуулга, үнэлгээ, сургалтын орчин, хугацаанд тавих шаардлагыг Стандартчлал, хэмжил зүйн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн стандартчлан баталгаажуулж 2014 оны 03 сард ШУТИС сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Үүнд: 1. MNS 5323-120:2011, Дээд боловсрол. Мэргэжлийн чиглэл: Үйлдвэрлэлийн дизайн, Индекс: D543700 Дараагийн удаад нь Монгол улсын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж эхэлсэн боловсролын салбарт хийх шинэчлэлийн ажлын хүрээнд БШУЯ-ны сайдын 2014 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/78 тоот тушаалаар батлагдсан бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ийн дагуу шинэчилсэн юм. Энэхүү тушаалаар батлагдсан дээд боловсролын шинэчлэл, өөрчлөлтөөр “Мебель модон эдлэлийн дизайн”, “Эдэлхүүний дизайн”, “Сав баглаа боолын дизайн” мэргэжлүүдийг нэгтгэн “Үйлдвэрлэлийн дизайн” хөтөлбөр болгон боловсруулсан бөгөөд ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2014 оны 08 сарын 11-ны өдрийн хурлаар хэлэлцэн Ректорын баталснаар 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн шинэ хөтөлбөрөөр элсэлт авч эхэлсэн болно.

**Үйлдвэрлэлийн дизайн. Элсэгч, төгсөгчийн харьцаа /сүүлийн зургаан жилээр/**

Д/д	Хичээлийн жил	Элсэгчдийн тоо	Төгсөгчдийн тоо
1	2015-2016 он	45	-
2	2016-2017 он	55	-
3	2017-2018 он	39	23
4	2018-2019 он	40	19
5		0	22
6	2020-2021	28	31

**Хувцасны дизайн.** ПДС-ийн Механик технологийн факультетийн Хөнгөн үйлдвэрийн тэнхмийн харьяанд 1986 онд “Оёмол бүтээгдэхүүний технологи” мэргэжлээр анхны элсэлтээ авснаар Хувцас судлалын салбарын суурь тавигдан 1991 нд оёдлын салбарын анхны 18 инженер бэлтгэгдэн гарсан түүхтэй. Түүнээс хойш 1992 онд “Оёмол бүтээгдэхүүний загвар зохион бүтээлт”, 2000 онд “Хувцасны дизайн” мэргэжлийн ангиудыг Монгол улсдаа анхлан нээж дээд боловсролтой инженер технологичдыг бэлтгэх их үйлсэд хувь нэмрээ оруулсаар иржээ.

Тус сургуулийн Дизайны салбар нь оюутны бүтээлч сэтгэлгээ, үйл ажиллагааг дээшлүүлэхэд байнга анхаарч ирсэн бөгөөд “Урлахуйн ертөнц”, “Торгон зам”, “Шилдэг даашинзны уралдаан” зэрэг мэргэжил сурталчлах уралдаан, наадмыг 2010 оноос амжилттайгаар зохион явуулж эхэлсэн бөгөөд одоо жил бүр оюутан сурагчдын хүсэн хүлээдэг, авъяас чадвараараа өрсөлддөг бүтээлч наадам болоод байна. МДХ-оос жил бүр зохион байгуулдаг “Хаврын гоёл–Дизайн сургалт” тэмцээн наадмын “Хувцас загварын уралдаан”, “Эрдэм шинжилгээний хурал”-д 2001-2017 онуудад тогтмол амжилттай оролцож ирсэн нь мэргэжлийн багш нар, оюутнуудын бүтээлч

хамтын ажиллагааны илрэл юм. 2007-2013 онуудад БНСУ-ын Хувцасны дизайны холбооны үзэсгэлэн, 2019 онд ӨМӨЗО-ны уралдаанд багш оюутны бүтээлүүдээр оролцож шагналт байранд шалгарч байсан нь тухайн салбарын бахархам амжилт билээ.

2000-2001 оны хичээлийн жилээс “Хувцасны дизайн” мэргэжлийг шинээр батлуулан 20 жилийн турш тасралтгүй сургалт явуулж ирсэн бөгөөд энэ хугацаанд Хувцасны дизайн мэргэжлээр нийт 217 оюутныг бакалаврын, 17 оюутныг дипломын зэргээр, Оёмол бүтээгдэхүүний загвар зохион бүтээгч-Хувцасны дизайн хос мэргэжлээр (MNS 5323-119:2011 D543600 "Хувцасны дизайн", MNS 5323-121:2011, D544000 "Оёмол бүтээгдэхүүний загвар зохион бүтээлт" мэргэжлийн стандарт) 15 оюутныг бакалаврын зэрэгтэйгээр, мөн 20 гаруй оюутныг магистрын зэрэгтэйгээр төгсгөсөн.

**Элсэгч, төгсөгчийн харьцаа /сүүлийн таван жилээр/**

Үзүүлэлт	2015-2016		2016-2017		2017-2018		2018-2019		2019-2020	
	нама р	хава р	нама р	хава р	нама р	хава р	нама р	хава р	нама р	хава р
Элсэгчийн тоо	11		46		39		39		11	
Төгсөгчийн тоо	11	8	3	8	5	10	8	5	4	14



Хомсдолтой ажил мэргэжил, 2014-2020 он

2020	2019	2018	2017	2016	2015	2014
Ажил мэргэжлийн нэр						
Туслах ажилтан, барилгын туслах	Мухлаг /лангууны худалдагч	Засалчин, шаварчин	Худалдагч	Жолооч	Зөөгч	Сүлжигч
Жолооч, машины	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	Их эмч	Мужаан	Мужаан	Эмч	Барилгын туслах
Тогооч	Цэвэрлэгч, албан байгууллагын	Тогооч	Тогооч	Тогооч	Тогооч	Засалчин
Дэлгүүрийн кассчин	Зөөгч	Барилгын ажилтан туслах	Жолооны багш	Байгаль хамгаалагч	Цахилгаанчин	Худалдагч
Засалчин, шаварчин	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	Модон бүтээгдэхүүний мужаан	Цэцэрлэгийн багш	Сүлжигч	Засал чимэглэл	Хүнсний технологич
Барилгачин	Эмийн сангийн эм зүйч /эмийн худалдааны/	Жолооч	Эм найруулагч	Дуу хөгжмийн багш	Сантехникч	Мэдээллийн ажилтан
Цэвэрлэгч, албан байгууллагын	Тогооч, ерөнхий	Сантехникч	Нядагч	Хамгаалалтын ажилтан	Мужаан	Бетон арматурчин
Харуул, гэрээт албаны	Харуул, гэрээт албаны	Худалдагч	Засалчин шаварчин	Цахилгаанчин	Гагнуурчин	Гагнуурчин
Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	Оёдолчин, зөөлөн эдлэлийн	Оёдолчин	Тоног төхөөрөмжийн засварчин	Авто засварчин	Жолооч	Хамгаалагч
Туслах ажилтан, барилга буулгах	Гагнуурчин	Арматурчин	Оёдолчин	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн	Үйлдвэрийн туслах ажилтан	Киттелчин
Жолооч, тэргэнцрийн /уул уурхайн/	Мухлаг /лангууны худалдагч	Хөргөлтийн инженер	Хамгаалагч	Эмч	Сувилагч	Цутгагч
Аудитор	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	Барилгын мужаан	Үсчин	Гагнуурчин	Механик инженер	Цахилгаанчин
Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /борлуулалтын/	Цэвэрлэгч, албан байгууллагын	Гагнуурчин	Хүнсний технологич	Дулааны инженер	Гадаад хэлний багш	Маркетинг борлуулалт
Фермийн ажилтан, мэргэшсэн /сүүний/	Нарийн мужаан	Албан байгууллагын үйлчлэгч	Арматурчин	Нэвтрүүлэгч	Барилгын туслах ажилтан	Сувилагч
Савлагч /гараар/	Туслах ажилтан, барилга угсралтын	Үйлдвэрийн ажилтан	Кеттель машин баригч	Зөөгч	Өндрийн буулт хийгч	Авто замын инженер
Зөөгч	Бармен	Борлуулагч	Зөөгч	Сантехник слесарь	Арматурчин	Худалдааны төлөөлөгч
Нарийн мужаан	Эм найруулагч	Кассчин	Хөдөө аж ахуйн механикжуулагч	Үйлчлэгч	Инженер	Үйлдвэрийн туслах ажилтан
Зэрэг тогтоогч, махны	Борлуулагч	Нягтлан бодогч	Сувилагч	Сувилагч	Нярайн сувилагч	Жолооч
Инженер, барилгын технологийн	Багш, бага ангийн /мэргэжлийн/	Хүнсний технологич	Үйлчлэгч	Соробан багш	Хүнсний ногоо тариалагч	Сантехникч
Графикч дизайнч, зураглаач	Гал тогооны туслах ажилтан	Жижүүр	Барилгын инженер	Нягтлан бодогч	Программ хангамжийн инженер	Шаварчин, өрлөгчин



2021 оны ажиллах хүчний эрэлт, ажил мэргэжлээр

Д/д	Код	Ажил мргэжлийн нэр	Ажиллах хүчний эрэлт
1	832211	Жолооч, машины	3904
2	931211	Туслах ажилтан, барилгын туслах	2761
3	335916	Мэргэжилтэн, итгэмжлэлийн үнэлгээний, баталгаажуулалтын	2123
4	711511	Барилга угсралтын мужаан	1845
5	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	1524
6	612111	Мах, цагаан идээ үйлдвэрлэгч	1101
7	343411	Тогооч	1046
8	541411	Харуул, гэрээт албаны	1004
9	752222	Нарийн мужаан	940
10	122111	Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /борлуулалтын/	826
11	331314	Нягтлан бодогч, төлбөр тооцооны	822
12	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	818
13	333412	Менежер, үл хөдлөх хөрөнгийн	760
14	523011	Дэлгүүрийн кассчин	734
15	332211	Төлөөлөгч, борлуулалтын	680
16	521111	Мухлаг /лангууны худалдагч	679
17	122112	Дарга, эрхлэгч /менежер/, алба, хэлтэс, тасгийн /маркетингийн/	623
18	721214	Гагнуурчин	603
19	214111	Инженер, аж үйлдвэрийн	573
20	222102	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	570
21	962113	Ачаа тээш хүргэгч	566
22	513111	Зөөгч	507
23	931311	Туслах ажилтан, барилга угсралтын	506
24	331113	Брокер, үл хөдлөх хөрөнгийн	500
25	711111	Барилгачин	490
26	911211	Цэвэрлэгч, албан тасалгааны	487
27	741111	Цахилгаанчин	486
28	723339	Засварчин, зүтгүүрийн	471
29	612120	Фермийн ажилтан, мэргэшсэн /сүүний/	444
30	214211	Инженер, барилгын технологийн	439
31	711411	Арматурчин	438
32	811131	Засварчин, хөдөлгүүрийн	432
33	833213	Жолооч, ачааны тэрэгний	425
34	712311	Засалчин, шаварчин	421
35	522313	Дэлгүүрийн туслах ажилтан	420
36	121112	Дарга, эрхлэгч /менежер/, алба, газар, хэлтэс, тасгийн /нягтлан бодох бүртгэлийн/	400
37	216612	Графикч дизайнч, зураглаач	389
38	331313	Нягтлан бодогч, хөндлөнгийн хяналтын	383
39	214219	Инженер, барилга угсралтын	370
40	422511	Мэдээлэл, лавлагаа хариуцсан ажилтан	351

Хүснэгт 5.5. 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн эдийн засгийн идэвхийн өөрчлөлт, ЭЗҮА-ны салбараар

Хэмжих нэгж: хувь

2017 онд ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2019 оны ЭЗИ-ийн төлөв			Бүгд
	Ажилтай хэвээр	Ажилгүй болсон	Э.З идэвхгүй болсон	
Урлаг, үзвэр, тоглоом наадам	92.6	0.5	6.9	100.0
Барилга	92.4	1.4	6.3	100.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	90.6	0.0	9.4	100.0
Уул урхай, олборлолт	90.5	1.2	8.3	100.0
Санхүү болон даатгалын үйл ажиллагаа	88.8	1.0	10.2	100.0
Мэргэжлийн, шинжлэх ухааны, техникийн үйл ажиллагаа	88.3	0.0	11.7	100.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа	85.5	0.3	14.2	100.0
Боловсруулах үйлдвэрлэл	85.4	2.4	12.2	100.0
Боловсрол	84.7	1.9	13.4	100.0
Мэдээлэл, холбоо	84.3	1.1	14.6	100.0
ХАА, ойн аж ахуй, загас, ан агнуур	81.8	1.0	17.3	100.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	4.2	14.7	100.0
Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	79.9	1.5	18.6	100.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	79.7	0.8	19.5	100.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамж	78.5	3.9	17.6	100.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	75.3	15.1	9.6	100.0
Ус хангамж, бохир зайлуулах систем, хог хаягдлын менежмент	73.0	0.0	27.0	100.0
Зочид буудал, байр сууц, нийтийн хоолны үйлчилгээ	72.2	2.2	25.6	100.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	68.0	1.7	30.3	100.0

